



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар A/85

Улаанбаатар хот

ШУТИС-ийн магистр, доктор оюутны  
эрдэм шинжилгээний хурал  
зохион байгуулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 10.2 дугаар заалт, ШУТИС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг удирдамжид заагдсан хугацаанд зохион байгуулсугай.
2. Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Эрдэм шинжилгээний хуралд магистрантур, докторантурт суралцаж буй оюутнуудыг өргөнөөр оролцуулахыг бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын төвийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарт даалгасугай.
4. Тус арга хэмжээтэй холбогдох зардлыг батлагдсан төсвийн дагуу гаргахыг Эрдэм шинжилгээ, технологийн газрын захирал (Д.Цолмонбаатар), Эрдэм шинжилгээ, хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Мөнхцэнгэл), магистр, доктор оюутны кредитийн урамшуулал тооцохыг бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын төвийн ахлах нягтлан бодогч нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ

Т.НАМНАН



367040447



МАГИСТР, ДОКТОР ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2023.03.10

Улаанбаатар хот

ШУТИС-ийн Ректорын 2011 оны А-63 тоот тушаалаар баталсан "ШУТИС-д магистр, доктор (Ph.D)-ын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам"-ын 9.25, 9.26 дугаар заалтуудыг үндэслэн ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах, магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын өгөөжийг дээшлүүлэх, бүрэлдэхүүн сургууль, төвийн эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлж шалгарсан шилдэг судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэх, сурталчлах, хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

Эрдэм шинжилгээний хурлыг дараах үндсэн чиглэлүүдээр зохион байгуулна. Үүнд:

1. Техникийн ухаан
2. Байгалийн ухаан
3. Нийгэм, хүмүүнлэгийн ухаан

*Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах хугацаа, үе шат*

ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг дөрвөн үе шаттайгаар зохион явуулна.

*Нэгдүгээр шат:* Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын төв дээр магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 3 дугаар сарын 24-31-ний хооронд тус тус зохион байгуулна.

*Хоёрдугаар шат:* Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын төв дээр зохион байгуулагдсан магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлаас магистр оюутны 3, доктор оюутны 3 илтгэлийг тус тус хянан магадалж, шаардлага хангасан бүтээлийг 2023 оны 4 дүгээр сарын 05-ны дотор Ахисан түвшний хөтөлбөрийн албандаа хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

*Гуравдугаар шат:* 2023 оны 4 дүгээр сарын 05-25-ны хооронд бүрэлдэхүүн болон харьяа сургууль, төвөөс ирүүлсэн бүтээлүүдэд хяналтын магадлагаа хийнэ.

*Дөрөвдүгээр шат:* ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 27, 28-ны өдөр зохион байгуулж, шилдэг илтгэлийг шалгаруулна.

*Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлд тавигдах шаардлага*

Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлд дараах шаардлагыг тавина. Үүнд:

1. Судалгааны ажлын зорилго, зорилт тодорхой, асуудал дэвшүүлсэн байх;
2. Шинжлэх ухаан, инновацийн шинэлэг тал, үр дүнг тодорхой тусгасан байх;
3. Судалгааны ажлын арга, аргачлалыг тодорхой гаргаж өгөх;



4. Судлаачдын бүтээлээс магистрант 6-аас доошгүй, докторант 12-оос доошгүй эшлэл авсан байх;
5. Бүтээлийн хуулбарлалтыг шалгуулсан байх;
6. Илтгэх ур чадварыг эзэмшсэн байх;
7. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлд хэвлүүлэх эрдэм шинжилгээний өгүүллийн шинэчилсэн загварын дагуу бичигдсэн байна.

ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хуралд дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

1. Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын төвийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэр;
2. Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих зааврын дагуу өгүүллийг бичиж ирүүлнэ.
3. Эрдэм шинжилгээний өгүүллийн агуулгын давхцалын хувь хэмжээ 40 хувиас доош байна. Агуулгын давхцалыг шалгасан хуудсыг хавсаргана.
4. Эрдэм шинжилгээний өгүүллийг ШУТИС-ийн ерөнхий редакцийн зөвлөлийн гишүүд уншиж, баталгаажуулсан байна.
5. Дээрх зааврын дагуу бэлтгээгүй, шаардлага хангаагүй бүтээлийг хүлээж авахгүй.

#### *Шалгаруулалт ба шагнал урамшуулал*

ШУТИС-ийн Захирлын тушаалаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийг шалгаруулна. Салбар, чиглэл бүрээр ирүүлсэн илтгэлийг хөтөлбөрийн дагуу хэлэлцэж, салбар бүрээс магистрант, докторантын 3, 3 илтгэлийг тус тус шалгаруулж урамшуулна.

#### *Техникийн ухааны салбар*

- |          |                                   |
|----------|-----------------------------------|
| I байр   | Батламж, 2.5 кредитийн урамшуулал |
| II байр  | Батламж, 2.0 кредитийн урамшуулал |
| III байр | Батламж, 1.5 кредитийн урамшуулал |

#### *Байгалийн ухааны салбар*

- |          |                                   |
|----------|-----------------------------------|
| I байр   | Батламж, 2.5 кредитийн урамшуулал |
| II байр  | Батламж, 2.0 кредитийн урамшуулал |
| III байр | Батламж, 1.5 кредитийн урамшуулал |

#### *Нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбар*

- |          |                                   |
|----------|-----------------------------------|
| I байр   | Батламж, 2.5 кредитийн урамшуулал |
| II байр  | Батламж, 2.0 кредитийн урамшуулал |
| III байр | Батламж, 1.5 кредитийн урамшуулал |

Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийг "ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл"-д өгүүлэл болгон хэвлүүлж, магистрант, докторант нарт эмхэтгэлийг хүргүүлнэ.

Ахисан түвшний хөтөлбөрийн алба  
Судалгаа, хөгжүүлэлтийн алба



**Шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл шалгаруулах  
комиссийн бүрэлдэхүүн**

Комиссын дарга	Эрдэм шинжилгээ, технологийн газрын захирал	доктор(Ph.D), профессор Д.Цолмонбаатар
Нарийн бичгийн дарга	Ахисан түвшний хөтөлбөрийн албаны ахлах мэргэжилтэн	доктор(Ph.D), профессор Ц.Оюун
Гишүүд	Ахисан түвшний хөтөлбөрийн албаны дарга Судалгаа, хөгжүүлэлтийн албаны дарга Ахисан түвшний хөтөлбөрийн албаны ахлах мэргэжилтэн Ахисан түвшний хөтөлбөрийн албаны мэргэжилтэн Судалгаа, хөгжүүлэлтийн албаны мэргэжилтэн БАС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга БАТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга БүХС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ГХС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ГҮУС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга МехТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга МХТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ЙТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ХШУС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ЭХС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ДарТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Нээлттэй боловсролын төвийн захирал "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль	доктор(Ph.D), профессор Д.Оюунцэцэг доктор(Ph.D), дэд профессор Ж.Арслан магистр Д.Батдорж магистр А.Оюундэлгэрэх магистр Ж.Батбаяр доктор(Ph.D) Б.Аюурзана доктор(Ph.D) О.Тамир доктор(Ph.D), дэд профессор Д.Бямбасүрэн доктор(Ph.D), дэд профессор Н.Мэнд доктор(Ph.D), дэд профессор О.Мөнхцэцэг доктор(Ph.D), дэд профессор Н.Пүрэвдорж доктор(Ph.D) Х.Загарзусэм доктор(Ph.D), дэд профессор М.Пүрэвжав доктор(Ph.D) Д.Отгонбаяр доктор(Ph.D) Д.Үлэмж доктор(Ph.D), дэд профессор Д.Баясгалан доктор(Ph.D), дэд профессор Д.Ганбат доктор(Ph.D) Д.Болор-Эрдэнэ